

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

ГАРЧИГ

| | |
|---|-----------|
| ОРШИЛ | 3 |
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ | 4 |
| 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл | 4 |
| 1.2 Төслийн байршил | 4 |
| 1.3 Төслийн хүчин чадал | 5 |
| 1.5 Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал, түүнийг эргүүлэн ашиглах, зайлуулах арга хэмжээ | 13 |
| 1.6 Шингэн хог хаягдал | 14 |
| Ажиллах хүчний тоо, эх үүсвэр | 18 |
| 1.8 Төслийн эдийн засгийн үзүүлэлт | 19 |
| БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ | 20 |
| Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 22 |
| НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /УРГАМЛАН НӨМРӨГ ХАМГААЛАХ/ | 24 |
| Биологийн олонз янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө | 24 |
| Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө | 24 |
| Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө | 25 |
| Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 25 |
| Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал | 26 |
| БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь | 26 |

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|----------|
| Зураг 1. Төслийн байршлийн зураг | 5 |
| Зураг 2. Жуулчины баазын барилга байгууламж | 6 |
| Зураг 3. Дрийм говь жуулчны баазын харагдах байдал | 7 |
| Зураг 4. Шинээр нэмж барьсан рестораны нүүр тал | 7 |
| Зураг 5. Шинээр нэмж барьсан ресторан ар тал | 8 |
| Зураг 6. Гэр буудлуудын гадна талаас харагдах байдал | 9 |
| Зураг 7. Гэр буудлын дотор тохижилт | 9 |
| Зураг 8. Гэр буудлын дотор талын тохижилт ариун цэврийн өрөө | 9 |
| Зураг 9. “ДРИЙМ ГОВЬ” жуулчны баазын гадна тал, орчны тохижилт | 10 |
| Зураг 10. Жуулчны баазын эргэн тойронд мод суулгац тарьсан байдал | 11 |
| Зураг 11. Гэр буудлын хооронд байрлах явган хүний зам | 12 |
| Зураг 12. Бааз руу ирдэг зам | 13 |
| Зураг 13. Хогийн төв ангилан ялгаж зайлуулдаг цэг | 14 |
| Зураг 14. Аtmoг бохир ус цэвэршүүлэх төхөөрөмж | 16 |
| Зураг 15. Бохир усны худаг болон соруулдаг цэг | 17 |
| Зураг 16. Цагаан хэрэглэлийн угаалага инүүлэгийн өрөө | 18 |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|-----------|
| Хүснэгт 3. Ажиллах хүчний тоо | 18 |
| Хүснэгт 4. хөрөнгө оруулалтын төлөвлөгөө | 19 |
| Хүснэгт 5. Барилга, байгууламжийн төлөвлөгөө | 19 |
| Хүснэгт 6. Борлуулалт /сар, жилээр/ | 19 |
| Хүснэгт 7. Цалингийн зардал /сар, жилээр/ | 19 |
| Хүснэгт 13. Нэгдсэн дүн | 21 |
| Хүснэгт 14. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 22 |
| Хүснэгт 15. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ургамлан нөмрөг хамгаалах/ | 24 |
| Хүснэгт 16. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 25 |

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

| | |
|--|----|
| Хүснэгт 17. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал | 26 |
| Хүснэгт 18. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь..... | 26 |
| Хүснэгт 19. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) | 28 |

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

ОРШИЛ

Өмнөговь аймгийн Булган сумын нутагт орших “ЖАМОТОРОБЭРҮ” ХХК-ний “ДРИЙМ ГОВЬ” Жуулчны бааз байгуулах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн ажлыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үндэслэн гэрээний дагуу хийж гүйцэтгэв.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах хянан батлах тайлагнах журамыг”, БОАЖЯ-ны байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт зэрэг эрхзүйн баримтуудыг баримталж гүйцэтгэв.

Жуулчны бааз байгуулах төсөл нь орчин үеийн шийдэл бүхий аялал жуулчлал амралтын стандарттаар үйл ажиллагаагаа явуулан гадаадын амрагч хүлээн авч нүүдлийн соёл иргэншлийг сурталчлах, иргэдэд найрсаг үйлчлэх, үйлчилгээний хувьд олон улсын жишиг стандарт эрүүл ахуйн шаардлагад нийцсэн иж бүрэн үйлчилгээг үзүүлэн тухайн орчны газар нутгийг зөв зохистой ашиглан хамгаалж экологийн цэвэр орчныг ханган, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилготойгоор 64 гэр буудлаас гадна 2 давхар үйлчилгээний байр баригдсан болно.

Хэрэгжиж буй төсөлтэй холбогдол бүхий л мэдээ, материал цуглуулж танилцсаны дараа уг талбай дээр манай компанийн мэргэжилтнүүд нэмэлт судалгаа явуулсан бөгөөд эдгээр мэдээллээ нэгтгэн дүгнэсний үр дүнд тулгуурлан энэхүү тайланг боловсруулав.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр

Өмнөговь аймгийн Булган сумын нутагт орших “ЖАМОТОРОБЭРҮ” ХХК-ний “ДРИЙМ ГОВЬ” жуулчны бааз

Төслийн үндэслэл, зорилго

Өмнөговь аймгийн Булган сумын нутаг Дал баг Хонгор толгой хэмээх газар орших байгалийн үзэсгэлэн бүрдсэн нутагт гадаад дотоодын амрагч, жуулчдад үйлчлэх олон улсын чанар, стандартад нийцсэн ажил үйлчилгээ явуулах, улмаар орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх, мөн энд говийн үзэсгэлэнгээс гадна ховор нандин байгалийн үзвэр болох эртний үлэг гүрвэлийн яс байдаг ба түүнийг үзэхээр зорин ирэх гадаад, дотоодын жуулчдад тухлан саатах боломжийг хангах зэрэг үйл ажиллагаа явуулахад төслийн гол зорилго, ач холбогдол оршино.

Төсөл хэрэгжүүлэгч


Япон, Монголын хамтарсан хөрөнгө оруулалттай “ЖАМОТОРОБЭРҮ” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9019047005, Регистрийн дугаар: 5274974

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг

Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 3-р хороо, Peace TOWER , 1608 тоот Утас: 315379, 99054550, Захирал И. Баттуяа

1.2 Төслийн байршил


Төсөл хэрэгжүүлэх нутаг нь Өмнөговь аймгийн Булган сумын нутаг Дал баг Хонгор толгой хэмээх нэртэй 2.0 га газар болно. Өмнөговь аймгаас Булган сум явах төв зам дагуу /өндөр хүчдэлийн шугамаас 1.5 км-ийн зайтай / байрлана.



Газарзүйн солбилцол нь:

| | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|--------|-------|--------|---------|-------|--------|
| | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | 103 | 51 | 45.97 | 43 | 54 | 29.46 |
| 2 | 103 | 51 | 51.59 | 43 | 54 | 33.09 |
| 3 | 103 | 51 | 50.25 | 43 | 54 | 34.18 |
| 4 | 103 | 51 | 54.19 | 43 | 54 | 36.73 |
| 5 | 103 | 52 | 0.21 | 43 | 54 | 31.87 |
| 6 | 103 | 51 | 50.64 | 43 | 54 | 25.69 |

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 1. Төслийн байршлийн зураг

1.3 Төслийн хүчин чадал

2009 онд 80-100 хүнийг нэг ээлжинд хүлээн авах хүчин чадалтайгаар нээгдэж байсан. 2018-2023 онд 64 гэрт нэг ээлжинд 100-160 хүн хүлээн авч үйлчлэх боломжтой болж өргөжин тэлсээр байна. Тус баазад ирж байгаа жуулчдын 80% нь европын жуулчид ирдэг учир тав тухыг нь хангах үүднээс монгол 5 ханатай гэрээ 1м 80 см өндөр хаалга болон модон карказан ханатай болгож 26 гэр өөрчлөж барьсан. 14 гэрийг люкс зэрэглэлийн тавилагатайгаар шинээр барьсан. Хуучин 24 гэрийг зөвхөн хаалгыг 1м 80см өндөртэй болгож сайжруулсан.

2022 онд 3 янзын зэрэглэлтэй 64 гэртэй болгож хүчин чадлаа нэмэгдүүллээ. Бүх гэрүүд дотороо 00 душтэй ба гурван янзын сонголтой.

1. Люкс
2. Хагас люкс
3. Энгийн гэсэн 3 зэрэглэлтэй

Тус баазад ашиглагдаж байгаа барилга байгууламжууд канад хаусан, цэвэр модон байшингууд учир гал унтраах хэрэгслээр баазыг бүрэн хангаж нийслэлийн галын аюулаас хамгаалах газартай хамтран байнга сургалт зохион байгуулж ажиллаа.

Мөн 3 гал тогоо хийн газар ашигладаг учир горгаз компанитай хамтран газ алдахаас урьчилан сэргийлж бүх ажилчдад жил бүр сургалт хийдэг. Барилгын гаднах болон дотроос цахилгааны утас мөн засвар үйлчилгээ үзүүлж байгаа. Баазын үйл ажиллагаа эхлэх үеэр бохирын хоолойнуудын шахаж засварлахыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж засч дуусгасан. Байгалийн үеэр усны аюулаас урьдчилан сэргийлэх үүднээс бүх гэрүүдийн шалыг цементээр цутгаж өндөрлөгөө хийсэн тул тав тухыг дээд зэргээр хангах бүрэн боломжтой.

Мөн жил ирэх тусам ирэх жуулчдын тоо нэмэгдэж байгаа учир хүчин чадлаа нэмэгдүүлэх ирсэн гадаад, дотоодын жуулчидын тав тух, сэтгэл ханамжыг өндөр байлгах үүднээс орчин үеийн шийдэл бүхий тансаг зэрэглэлийн рестароныг шинээр барьсан.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 2. Жуулчины баазын барилга байгууламж

Гэр буудал болон рестораныг холбосон чулуун явган хүний зам, хатуу хучилттай машины зогсоол, гэр буудал болон рестораны өмнө амрах сүүдрэвч байрлах бөгөөд үлдсэн талбай болох 30%-д ногоон байгууламжтай.

Төслийн барилга байгууламж, тоног төхөөрөмж:

Төслийн үйл ажиллагаа нь нийтийн хоол, гэр буудлын үйлчилгээ, душ, саун зэрэг үйлчилгээ үзүүлэх бөгөөд энэ талаар олон улсын жишигт дүйцэхүйц тоног төхөөрөмж суурилуулан нийтээр дагаж мөрддөг технологийн дагуу үйл ажиллагаа явуулна. Өмнөговь аймгийн Булган сумын дал баг хонгор толгой хэмээх газар орших байгалийн үзэсгэлэнт бүрдсэн нутагт гадаад дотоодын амрагч жуулчдад үйлчилж, олон улсын чанар стандартад нийцсэн ажил үйлчилгээ үзүүлж улмаар орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх зорилготой.

Баазад ашиглах тоног төхөөрөмж, үйлчилгээг жагсаавал:

1. Нарны энергээр асдаг гэрэлтүүлэг
2. Бага оврын цахилгаан үүсгэгч
3. Сүүдрэвч
4. Хөргөгч, хөлдөөгч
5. Агааржуулагч (aircondition)
6. Угаалгын машин
7. Индүүдлэгийн өрөө
8. Цэвэрлэх байгууламж

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 3. Дрийм говь жуулчны баазын харагдах байдал



Зураг 4.Шинээр нэмж барьсан рестораны нүүр тал

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 5. Шинээр нэмж барьсан ресторан ар тал




**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 6. Гэр буудлуудын гадна талаас харагдах байдал



Зураг 7. Гэр буудлын дотор тохижилт



Зураг 8. Гэр буудлын дотор талын тохижилт ариун цэврийн өрөө

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 9. “ДРИЙМ ГОВЬ” жуулчны баазын гадна тал, орчны тохижилт

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 10. Жуулчны баазын эргэн тойронд мод суулгац тарьсан байдал

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 11. Гэр буудлын хооронд байрлах явган хүний зам

1.4 Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн байдал

Усан хангамж – Төсөл хэрэгжүүлэх талбайд гүний худагтай. Түүнийгээ унд ахуйн хэрэгцээндээ ашиглана. Гүний худгийн гүн 97м, ундарга нь 9,0л/сек

Цахилгаан – Төсөл хэрэгжих орчимд дэд бүтэц шийдэгдсэн газар учир хамгийн ойр байрлах хүчдэлээс шугам татаж цахилгаанаа шийдсэн. Бага оврын цахилгаан үүсгүүртэй.

Дулаан хангамж – Зуны гурван сар ажилладаг. Ажиллаж байх хугацаандаа дулааны асуудлыг цахилгаанаар хангадаг.

Харилцаа холбоо Зам – Тус жуулчины бааз нь холбооны үүрэн телефон утастай бөгөөд төсөл хэрэгжиж буй газар Жи мобайлийн сүлжээ барьдаг.



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 12. Бааз руу ирдэг зам

1.5 Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал, түүнийг эргүүлэн ашиглах, зайлуулах арга хэмжээ

Төслийн үйл ажиллагаанаас энгийн хатуу, шингэн, аюултай хог хаягдал гарна.

Энгийн хог хаягдал

Аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг энгийн хог хаягдал гэж үздэг. Төслийн үйл ажиллагаанаас лааз, шил, хуванцар сав, гялгар уут, хоолны үлдэгдэл, цаас, ахуйн сав баглаа боодол зэрэг гарна.

Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлын тооцоо

Дунджаар тус амралтын баазын ажиллах хугацаа нь гэр буудал нь 3сар буюу 90 хоног ажиллахдаа өдөрт дунджаар нэг ээлжиндээ 100 - 160 хүлээн авах бөгөөд үүний 25%-аар бодоод өдөрт тогтмол 30 хүн, байнгын ажилчид 10 хүн ажиллана гэж үзвэл:

Зундаа: Нийт $40 \text{ хүн} * 0,3 \text{ кг} = 12,0 \text{ кг}$ 30 хоногт буюу сард 360кг, жилд ажиллах хугацаа нь 3 сар буюу 90 хоногоор тооцож үзвэл 1,08 тн орчим хатуу хог хаягдал гаргахаар байна.

Жуулчны баазад доорх нэр төрлийн хатуу хог хаягдал гаргахаар байна. Үүнд:

- Хүнсний зүйлийн сав,баглаа,боодол
- Бие засах газрын хаягдал
- Полиэтилен уут,баглаа,боодол
- Үнс
- Хоолны үлдэгдэл
- Бусад

Тус компани нь төслийг хэрэгжүүлэх явцдаа хатуу хог хаягдлыг зайлуулах асуудлыг “Хог хаягдлын тухай” улсын хуульд заасны дагуу холбогдох байгууллагатай “Хог хаягдал тээвэрлэн зайлуулах” гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэж байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь хатуу хог хаягдлын цэгийг баазынхаа зүүн урд талд ангилан ялгаж хийх тусгай цэг байгуулж ангилан ялгаж битүү саванд хийн гэрээний дагуу тогтсон цэгт зайлуулж байна.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 13. Хогийн төв ангиан ялгаж зайлуулдаг цэг.

Аюултай хог хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас нарны хавтан, цэнэг хураагуур, зай зэрэг аюултай хог хаягдал гарна. Манай улсад нарны хавтан, цэнэг хураагуур устгах арга хэмжээг хэрэгжүүлдэг байгуулага байдаггүй тул ханган нийлүүлэгчид буцаан өгөхөөр гэрээ байгуулж ашиглах шаардлагатай. Харин бусад зай болон батерейг металл худалдан авдаг газарт зориулалтын дагуу хадгалж байгаад өгөх хэрэгтэй.

Аюултай хог хаягдлыг түр хадгалах, тээвэрлэх арга хэмжээ

Аюултай хог хаягдал үүсгэгч болон аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч ... заасны дагуу бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан байна.

Аюултай хог хаягдлыг савлах

- Аюултай хог хаягдлыг ангиан ялгаж, зориулалтын саванд савлаж хадгалах
- Аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь аюултай хог хаягдал гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна.

Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах

- 1 сард 1000 килограммтай тэнцүү буюу түүнээс бага аюултай хог хаягдал үүсгэдэг бол 180 хоног
- 2 сард 1000 килограммаас их хэмжээтэй аюултай хог хаягдал үүсгэдэг бол 90 хоног
- Тодорхой шалтгааны улмаас хуулийн хугацаанаас илүү хугацаагаар хадгалах бол нийслэлийн хог хаягдлын менежментийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, түр хадгалах зөвшөөрөл авна.
- Аюултай хог хаягдлыг агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд хадгална.
- Аюултай хог хаягдлыг үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэнэ.
- Аюултай хог хаягдлыг хадгалах үед үүссэн шүүрлийг аюултай хог хаягдал гэж үзнэ.
- Аюултай хог хаягдал үүсгэгч нь зөвшөөр бүхий байгууллагад шилжүүлэхэд маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлнэ.
- Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдал хариуцсан орон тооны болон орон тооны бус ажилтантай байна.

1.6 Шингэн хог хаягдал

Төсөл хэрэгжих үеийн шингэн хаягдлын эх үүсвэр нь:

- Хоол бэлтгэлийн явцад гарсан бохир ус
- Цэвэрлэгээнд хэрэглэсэн бохир ус

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Ариун цэврийн өрөөнүүдээс гарах бохир ус зэрэг болно.

Төслийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх цэвэр ус, ялгаран гарах шингэн хаягдлын тооцоо

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар болон 14 дүгээр хавсралтан дээр үндэслэн тооцов.

Дунджаар тус амралтын баазын ажиллах хугацаа нь 3 сар буюу 90 хоногт өдөрт тогтмол 30 амрагч, 10 ажилчин гэж тооцвол: (1 амрагч өдөрт 180 л, 1 ажилчин өдөрт 50 л ус ашиглахаар тооцов)

Зундаа: 90 хоног* 30 хүн* 180 л/хоног= 486 м³ /амрагч/

90 хоног* 10 хүн* 50 л/хоног= 45 м³ /ажилчин/

Нийт хэрэглэх усны хэмжээ 1 жилд 531 м³ буюу 1 хоногт 5.9 м³ цэвэр ус ашиглахаар байна. Уг усны хэрэгцээг өөрийн төслийн талбайд гаргасан худгаас хангана. Үүний **70% буюу 371.7 тн/жилд** шингэн хаягдал гарах тооцоотой байна. Мөн нийт төсөл хэрэгжих талбай болох 5.0 га газрын 30%-д нь ногоон байгууламж болгохоор төлөвлөхөөр заасны дагуу эхний жилд 1200 м² талбайг зүлэгжүүлж мод бут гарина.

| Услах хоног | Давтамж | Усны хэрэглээ | Нийт талбай | Нийт усны хэмжээ |
|-------------|-----------------|----------------------|---------------------|----------------------|
| 153 | 7 хоногт 1 удаа | 1м ² =4 л | 1200 м ² | 105,6 м ³ |

АТМОП бохир ус цэвэршүүлэх төхөөрөмж

Төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаандаа атморын бага оврын цэвэрлэх байгууламжийг суурилуулан ашигладаг.

Уг систем нь манай орны цаг уур, нөхцөл байдалд тохируулан Монгол инженерүүдийн зохион бүтээсэн ахуйн бохир усыг аэрошны тусламжтайгаар ялган задалж, ялгаран тунасан шингэн хэсгийг нь нэмэлт шүүлтүүр болон газрын хөрсөөр шүүж, усыг 92% цэвэржүүлэн гаргадаг төхөөрөмж юм. Гарсан усыг хөрсөнд хаях ба зүлэг, ногоо услах, машин угаах зэрэг хоёрдогч хэрэглээнд ашиглах боломжтой.


1.Ажиллах зарчим

Цэвэрлэх байгууламж нь 4 үе шаттай бохир усыг цэвэрлэнэ.

2.Технологийн байгуулалт

Бохирын системийн бохир хүлээн авах оруулга нь газрын түвшингөөс 7м гүнд байрлахаар хийгдсэн тул шугам хоолойн уртаас хамаарч 1м хоолойд 0,7см хэвгий унаж байхаар тооцон объектын бохир усны гаргалгааны түвшинг тодорхойлно. Цэвэрлэх байгууламж хүртэлх шугамын диаметр нь Ф=100 PVC 0 хуванцар шар хоолой байх бөгөөд халдаг кабелиар 20см алслалттай ороон резинэн хар дулаалгаар дулаална.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 14. Atmor бохир ус цэвэршүүлэх төхөөрөмж

Бохир ус цэвэрлэх байгууламжаар дамжин 3 үе шаттай цэвэрлэгдсэний дараа шингээх худаг луу шилжих бөгөөд уг худаг нь газрын түвшингээс 1 м гүнд байрлана. Цэвэрлэгдсэн ус шингээх талбай луу шугам хоолойн уртаас хамаарч 1 м хоолойд 0,7 см хэвгийгээр унах бөгөөд хуванцар хоолой Ф=50 PVC-г халдаг кабелиар 20см алслалттай ороон резинэн хар дулаалгаар дулаална.

3. Дагуугийн зүсэлт

Бохир усны хэмжээ 1 м³/хоногос ихгүй үед элс, элсэрхэг хөрсөнд шүүрүүлэх худаг хийнэ. Худагийн суурь хөрсний усны түвшингээс дээш 1м-ээс багагүй зайтай байна.

1. Шүүрүүлэх худаг нь ф=319 диаметртэй даагийн хуванцар нүхтэй кольцо байна. Усыг шүүрүүлэн гаргах нүх нь худгийн хананд байна.
2. Шүүрүүлэх талбай нь 2х2 м-ээс ихгүй, гүн нь 2,5 м-ээс багагүй байна. Шүүрүүлэх гадаргын 1 м² талбайн ачаалал элсэн хөрсөнд 80л/хоног, элсэнцэр хөрсөнд 40 л/хоног байна.
3. Ёроолын шүүрүүлэх материалыг хөрснөөс шалтгаалан -2,5 м-ээс дээш 1 м хүртэлх зузаантай хайрга дэвсэж дээд түвшингүүдэд сайрга, бүхэлжсэн үнс болон бусад материал оролцуулана

4. Бохирын СЕПТИК системийг ашиглах зөвлөмж

Мөрдөх зарчимууд

- Засварын ажил хийхдээ мэргэжлийн хүмүүсийг ажиллуулах
- Тунгаагч сав, түгээх төхөөрөмжийг цэвэрлэх болон нэвтрэх нүхний таглаа өргөгчийг суурилуулж, тухайн таглаа нь байнга цоожтой байх эсвэл хүүхэд онгойлгохоос сэргийлж, хангалттай хүнд жинтэй байлгах
- Бохирын системээ жил бүр шалган үзэж, тунгаагч савыг 2-3 жил тутамд мэргэжлийн хүмүүсээр цэвэрлүүлэх хэрэгтэй
- Хяналт болон бусад засвар үйлчилгээнүүдийн тухай тэмдэглэл байнга хөтлөх

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Системийг хэт ачаалалд оруулахаас сэргийл. Ус байнга алддаг цорго, жорлонгийн бочкийг засаж, усанд орох, угаалгын машин болон аяга таваг угаагчийг хэрэглэхдээ ус хэт ихээр үр ашиггүй зарцуулахаас зайлсхийж, усны цорго болон шүршүүрийн толгойн хэсэгт форсунк суулгах болон жорлонд ус хэмнэх аргуудыг хэрэглэх
- Усны бусад эх үүсвэрүүд жишээлбэл дээврийн болон бороо, үерийн усыг бохирын систем руу орохоос сэргийлж, чиглэлийг нь өөрчлөх суваг, шуудуу хийх хэрэгтэй. Чиглэлийг өөрчлөхөд хана босгох, хавтгай гадаргуутай чиглэл өөрчлөгч зэргийг ашигла
- Гэр ахуйн бус аюултай химийн хаягдлыг бохирын системдээ хийхийг хориглох.

Хориглох зүйлс

- Шалтгаангүйгээр тунгаагч савруу бүү нэвтэр. Тунгаагч саванд хуримтлагдсан зарим хийнүүд нь амьсгал боогдуулж болно
- Бохирын системийн дээр машинаа тавих эсвэл машинаар явахыг хориглоно.
- Шингээгч худаг байрладаг талбайг асфальт эсвэл бетоноор бүрхэж болохгүй. Зүлэг тарих нь хамгийн зөв бөгөөд зөвхөн элэгдлээс хамгаалаад зогсохгүй илүүдэл усыг ч гадагшлуулдаг
- Бохирын хоолойруу техникийн тос тосолгооны материал, шатахуун, химийн бодис, будаг, фото зургийн шингэн, пестицид зэргийг хийхийг хориглоно. Тэдгээр нь тунгаагч саван дахь бактерийн үйл явцыг хямралд оруулж улмаар хөрсний усыг бохирдуулдаг
- Жорлонгоо хогийн сав мэтээр хэрэглэхийг хориглоно. Жорлонд кофены нунтаг, яс, тамхины иш, эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэгсэл, цаас, салфетка зэрэг амархан бөглөрөл үүсэгдэг бусад материалуудыг хийхийг хориглоно.
- Хэрвээ ТС-д хог хаягдал ихээр хийвэл цэвэрлэх давтамж 50%- иар ихсэх магадлалтай гэдгийг анхаарвал зохино
- Тунгаагч сав руу энзим болон түүхий дрож зэрэг бактерийн үйл явцыг хэт ихэсгэдэг бодис оруулж болохгүй. Энэ нь хөрсний бүтцэд нөлөөлж ургамал ургахад сөргөөр нөлөөлж хөрсний усыг бохирдуулна.



Зураг 15. Бохир усны худаг болон соруулдаг цэг

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 16. Цагаан хэрэглэлийн угаалага инүүлэгийн өрөө

Ажиллах хүчний тоо, эх үүсвэр

Уг төсөл хэрэгжихэд нийт 10 хүн ажиллах болно. Төслийн удирдлага зохион байгуулалт дараах бүтэцтэй байх бөгөөд удирдах ажилтнуудыг өндөр зэрэглэлийн зочид буудал амралтын газрын удирдлагаар сургана. Мөн ажилчдын нийгмийн баталгаа, хөгжих орчныг бүрдүүлэхийн тулд байнгын сургалт зохион байгуулна.

Хүснэгт 1. Ажиллах хүчний тоо

| № | Эрхэлж буй ажил | Ажилчдын тоо |
|---|----------------------|--------------|
| 1 | Захирал | 1 |
| 2 | Нярав | 1 |
| 3 | Үйлчилгээний ажилтан | 4 |
| 4 | Тогооч | 2 |
| 5 | Зөөгч | 2 |

Дээрх мэргэжлийн хүмүүс нь доорх үүрэг хариуцлагатайгаар ажил үүргээ гүйцэтгэнэ.

Ерөнхий зүйл:

1. Монгол улсын хөдөлмөрийн хуулийг удиртгал болгон хөдөлмөрийн гэрээ байгуулж ажил үүргийн тодорхойлолтын дагуу ажиллана.
2. Ажлын байрандаа цагийг нарийн баримтлан ажилдаа хоцрохгүй, ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрөөх
3. Ажлын байранд архи, тамхи хэрэглэхгүй байх
4. Цаг үргэлж цэвэр цэмцгэр байж, ажлын формыг өмсөх
5. Тодорхой шалтгаанаар ажилдаа ирэх боломжгүй бол удирдлагад урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авах, өвчилсөн тохиолдолд эмнэлгийн хуудас авчирах
6. Байгууллагын эд хогшил, тоног төхөөрөмжийг ариг гамтай ашиглаж хувьдаа ашиглахгүй байх
7. Хамт олон болон үйлчлүүлэгчидтэйгээ зөв боловсон харьцаж тэдний тавьсан хүсэлтийг хөнгөн шуурхай биелүүлэх
8. Захиргаанд санал хүсэлтээ тавих, асуудал боловсруулан хэлэлцүүлж, ахуй амьдрал, цалин тэтгэмж, тусламжийн талаар санал хүсэлт тавих эрхтэй.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.8 Төслийн эдийн засгийн үзүүлэлт

Хүснэгт 2. хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

| № | Нийт хөрөнгө оруулалт | Дүн |
|---|-----------------------|---------------------|
| 1 | Барилга, байгууламж | 870,000,000 |
| 2 | Тоног төхөөрөмж | 330,000,000 |
| | Нийт дүн | 1200 000 000 |

Баазад эхний ээлжинд үндсэн 2 чиглэлд хөрөнгө оруулалт хийсэн. Эдгээр нь барилга, байгууламж, тоног төхөөрөмж юм.

Хүснэгт 3. Барилга, байгууламжийн төлөвлөгөө

| | Барилга, байгууламж | Бүгд өртөг |
|---|------------------------------|--------------------|
| 1 | Үйлчилгээний төв /2 давхар/ | 714,000,000 |
| 2 | Барилгын зураг төсөл | 6,000,000 |
| 3 | Гэр | 70,000,000 |
| 4 | Цахилгаан, дулаан /3 объект/ | 80,000,000 |
| | НИЙТ | 870,000,000 |

Борлуулалт /бүтээгдэхүүн үйлчилгээний нэгжээр/

Жилд хүчин чадлаа 100%-ийн ашиглалттай ажиллавал хүлээн авч үйлчлэх боломжтой үйлчлүүлэгчдийн тоог доорх байдлаар таамаглан тооцоолов. Жуулчны бааз нь нэг жуулчин 1-2 хоног байрлана.

Хүснэгт 4. Борлуулалт /сар, жилээр/

| Бүтээгдэхүүний төрөл | Үнэ (төг) | Үйлдвэрлэх хэмжээ /сараар/ | Орлого /сараар/ | Орлого /жилээр/ |
|----------------------|----------------|----------------------------|-----------------|-----------------|
| Гэр буудал | 70 000 | 50 | 3,500,0 | 42,000,0 |
| Байшин | 80 000 | 40 | 3,200,0 | 38,400,0 |
| Нийт | 150,000 | 90 | 6,700,0 | 80,000,0 |

Хүснэгт 5. Цалингийн зардал /сар, жилээр/

| Эрхэлж буй ажил | Ажилчдын тоо | Үндсэн цалин | Нийт цалин |
|----------------------|--------------|--------------|------------|
| Захирал | 1 | 800,000 | 9.600.0 |
| Нярав | 1 | 500,000 | 6.000.0 |
| Үйлчилгээний ажилтан | 4 | 400,000 | 4.800.0 |
| Тогооч | 2 | 700,000 | 8.400.0 |
| Зөөгч | 2 | 400,000 | 4.800.0 |
| Нийт | 10 | 2.400.0 | 24.000.0 |

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“ЖАМОТОРАБЭРҮ” ХХК-ийн “ДРИЙМ ГОВЬ” жуулчны бааз байгуулах төслийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний (БОННУ) үр дүнг үндэслэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Хас Цаг” ХХК боловсруулсан болно. Уг байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн БОННУ-нд тусгасан одоогийн хүчин чадлын хэмжээнд үйл ажиллагаа явуулах хугацаанд хүчин төгөлдөр байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад холбогдох хууль, журам, стандартыг баримтлан, БОНХС-ын 2014 оны А-117 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулав.

Тус жуулчны баазын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ)
- Байгаль орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр (БОХШХ) гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ нь дараах зорилгуудыг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд: агаар, ус, хөрсөн бүрхэвч, ургамал, амьтан болон тухайн орчинд ажиллаж буй хүмүүст аялал цогцолборын үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох, дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг тодорхойлох, шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно. Байгаль хамгаалах төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн хураангуй бөгөөд жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай буюу байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулж байх шаардлагатай. Төслийн БОХТ-г боловсруулахдаа төсөл хэрэгжүүлж эхлэхээс өмнө төслийн төлөвлөлтөнд анхаарч тусгах арга хэмжээ болон цаашид төслийн хэрэгжилтийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан болохыг анхаарна уу.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийн хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, хугацааг тусгаж, шаардагдах хөрөнгө, зардлыг урьдчилан тооцсон болно. Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжих тухайн жилээр боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлын тооцоог зах зээлийн өнөөгийн үнийн дүнгээр тооцов.

Төсөл хэрэгжүүлэгч БОННУ батлагдсаны дараа жилээс эхлэн жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хариуцан боловсруулж, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль хамгаалах хууль тогтоомж, төслийн БОННУ-ний үр дүн, батлагдсан БОМТ (энэхүү төлөвлөгөө)-нд үндэслэл болгоно.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн болон хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12-р сарын 01-ний дотор орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд хүргүүлж хянуулан зохих шийдвэрийг гаргуулж ажиллах шаардлагатай.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 6. Нэгдсэн дүн

| Д/д | Бүрэлдэхүүн хэсгүүд | Тухайн жилийн зардал /мян. т/ |
|-----|--|-------------------------------|
| 1. | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 1740 |
| 2. | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ногоон байгууламжийн төлөвлөгөө/ | 1100,0 |
| 3. | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 4. | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 5. | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 6. | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 1150,0 |
| 7. | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 740,0 |
| 8. | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 218,0 |
| | | 4948,0 |

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМГОВЬ НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг /мян.төгрөг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|--|---|--|-----------------------------------|---------------------------------------|---|
| Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах урьдчилан сэргийлэх төлөвлөгөө | | | | | |
| Өмнөговь аймгийн Булган сумын Дал багийн Хонгор толгой орчмын авто машины хөдөлгөөн ихэссэнээс агаар, агаар дахь тоосны хэмжээ, CO, SO ₂ , NO ₂ ихсэж, орчны хүчилтөрөгчийн (O ₂) хэмжээ багасах, үйлчлүүлэгч, байгууллагын үйлчилгээний автомашины шатах тослох материалын ууршилт, утаа, тортог, хорт хий агаарт дэгдэж агаар орчинг бохирдуулах, ахуйн хог хаягдлын сав, бохир ус дамжуулах хоолой болон бохир ус цуглуулах хэсгийн битүүмжлэл муу байснаас үнэрийн бохирдол үүсэж болно. | Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид) болон олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлэх, | Төсөлийн хүрээнд хэрэглэгдэх авто тээврийн хэрэгсэлд | ҮАЗ | Улиралд тутамд | - Агаарын тухай хууль, - MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, - Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ - |
| Нийт дүн | | | | | |
| Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах урьдчилан сэргийлэх төлөвлөгөө | | | | | |
| Төслийн барилгажилтын үе шатанд /цэвэр бохир усны шугам, / гадаргын болон гүний усанд нөлөөлөх, Шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, Бохир ус дамжуулах шугам хоолойг зориулалтын бус материалаар хийх, шугам хоолойд гэмтэл үүсэж гүний усыг бохирдуулж болзошгүй. | Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгаа эсэхийг үе үе хянах, тухай бүр нэн даруй засвар хийх | Төсөлийн хүрээнд | ҮАЗ | Жилд 1 удаа | - Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS4586-98 (СХЗҮТ, 1998.5.28-ны өдрийн 17 тоот тогтоол.), Усан орчны чанарын хяналт шинжилгээ MNS4047-88 (УСТ-ын даргын 1988 оны 248 тоот тушаал), Усны чанар, хаягдал бохир ус. MNS 4943-2014 |
| | Усны хэрэглээнд хяналт тавьж үр ашигтай зарцуулалт бий болгож, усны дүгнэлт гаргуулж ажиллах | Төслийн хүрээнд | ҮАЗ | Тухай бүр | |
| | Зүлэг ногоо услах болон ахуйн хэрэглээнд ашиглахаар хурын ус | Төслийн эхэнд | 500,0 | Төслийн эхэнд | |

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| | | | | | |
|--|---|-----------------------------------|---------------|--------------------------|--|
| | цуглуулах, нөөцлөх бичил байгууламж хийх | | | | - ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/ |
| Нийт дүн | | | 500.0 | | |
| Хөрс ургамлын аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө | | | | | |
| Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс байгууламжуудын дор дарагдаж, зам тээвэр, бүтээн байгуулалт болон бусад үйл ажиллагаатай холбогдож элэгдэл, эвдрэлд өртөнө. Барилгын ажлын улмаас хаягдлаар хөрс бохирдож болзошгүй | Төслийн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, /төслийн хашаанаас гадна талбайд олон салаа зам гаргахаас сэргийлэх/ сэргээн засварлаж байх | Төслийн талбайд | 500.0 | | MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, - MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| | Ашигт ургамлын байршлыг тэмдэгжүүлж хамгаалалтад авах | Төслийн хариуцан хамгаалах талбай | 200,0 | Төслийн эхэнд | |
| | Төслийн объектууд хооронд явган хүний зам тавих (өнгөт хавтан, чулуу г.м), сэргээн засварлаж байх | Төслийн талбайд | 100,0 | Төсөл хэрэгжих хугацаанд | |
| Нийт дүн | | | 800.0 | | |
| Удирдлага зохион байгуулалт авах арга хэмжээнй төлөвлөгөө | | | | | |
| Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, БЦГ-ын хамгаалалтын захиргаа болон байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах | | Төслийн хүрээнд | 200.0 | Жилд 1 удаа | |
| Эрүүл мэндийн үзлэгт хамруулах. | | Ажилчид | 8x30,0=240,0 | Жилд 1 удаа | |
| | | | 440,0 | | |
| Нийт | | | 1740.0 | | |

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМГОВЬ НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ургамлан нөмрөг хамгаалах/

Тус аялал жуулчлалын цогцолбор байгуулах төслийн онцлогоос хамааран нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулахдаа төслийн талбайн ногоон байгууламжыг байгуулах болон түүний арчилгаа, тордолгоо хийх ажлыг оруулсан. Ногоон байгууламж байгуулах зөвлөмжийг төслийн БОННУ-д тодорхой тусгаж зардлын тооцоог гаргасан ба энэхүү зардлыг төслийн бүтээн байгуулалтын төсөвт суулгаж өгөх нь зүйтэй.

Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ургамлан нөмрөг хамгаалах/

| Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээх арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг /мян.төг/ | Нийт зардал /мян. төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|--|---|-----------------------------------|--------------------------------|------------------------------|---------------------------------------|--|
| Элэгдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээн, ногоон байгууламж бий болгох | Нийт ашиглалтын талбайн захаар эгнүүлэн 2 эгнээ сөөгөн хашлага хийх | Нийт талбайн захаар 150 ш | 150ш x 6000₮ | 900.0 | 2023он | Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт. MNS5914:2008; Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт. MNS5916:2008; Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. MNS5918:2008; |
| Тоосжилтоос сэргийлэх зорилгоор орчныг тохижуулж, зүлэгжүүлэхэд тогтмол усалгаа хийх | Ногоон байгууламжын усалгаа, тайралт, хэлбэржүүлэлт хийх | Төсөл хэрэгжих орчинд | | 200.0 | 2023онд | |
| Нийт | | | | 1100,0 | | |

Биологийн олонз янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг хууль эрхзүйн хүрээнд судална.

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

1 Хэрэв цаашид нүүрлэн шилжүүлэлт нөхөн олговортой холбоотой асуудал гарвал газар болон бусад үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой өмчлөх, хуваарилах, бэлэглэх, шилжүүлэх үйл явцыг Монгол улсад дараах хууль тогтоомжуудаар зохицуулна. Үүнд:

- 2 - Үндсэн хууль(1992);
- 3 - Газрын тухай хууль(2002);
- 4 - Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль(2003);
- 5 - Иргэний тухай хууль (2002) багтана.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олоход үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

Осол, эрдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Осол, эрдэлийн менежментийн төлөвлөгөө

| Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нийт зардал /мян.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|--|---|-----------------------|--------------------------------|--|
| Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх | Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах | Нийт төсөл хэрэгжих талбай, барилга байгууламжинд | 300,0 | Жилд 1 удаа | Гамшгаас хамгаалах тухай хууль, “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” |
| | Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах | Бүх ажилчдад | 150,0 | Жилд 2 удаа | |
| | Хамгаалалтын далан, жалга сайрыг цэвэрлэж байх | Төслийн талбай орчим | 100,0 | Жилд 2 удаа | |
| | Өөрийн байгууламжид үер усны аюул, гал түймрээс урьдчилан сэргийлэх тусгай бүдүүвч схем боловсруулан батлах | Төслийн хүрээнд | 100,0 | Төслийн эхэнд | |
| ХХАА | Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах | Бүх ажилчдад | 200,0 | Жилд 1 удаа | |
| | Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах | Баазын хэмжээнд | 300,0 | Жил бүр | |
| Нийт | | | 1150,0 | | |

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Хүснэгт 10. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

| Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Нийт зардал /мян.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|--|--|------------------------------------|--------------------------------|--|
| -Ахуйн хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох -Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй | Эко байр сууцны үйлчилгээнд энгийн нүхэн жорлонг ашиглахгүй ба байгальд ээлтэй технологи бүхий био жорлонтой байна. | Төслийн хүрээнд Атмор бага оврын цэвэрлэх байгууламжийг суурилуулан ашиглаж байна. | | Төслийн хүрээнд | - Хог хаягдлын тухай хууль - Ариун цэврийн тухай хууль - - MNS 6426:2013 - - Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, |
| | Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байх | Төслийн хүрээнд | ҮАЗ тусгаж хогийг зайлуулж хэвшсэн | Үйл ажиллагааны хүрээнд | |
| | Нийтийн эзэмшлийн талбай, үйлчилгээний орчинд хогийн сав байрлуулах, Байр сууц бүрт орчинтойгоо зохицсон материал, өнгө үзэмж бүхий хогийн савтай байх | Төслийн хүрээнд | 500,0 | Төслийн эхэнд | |
| | Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулж байх /сард 2 удаа/ | Төслийн хүрээнд | 4сарх 2 x 30,0=240.0 | 2023онд | |
| Хог хаягдлын менежментийн нийт зардал | | | 740.0 | | |

БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Хүснэгт 11. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

| БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд | Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр | Мэдээний агуулга | Хугацааны тов | Хэлэлцүүлгээр санал авах чиглэл | Зохион байгуулах газар |
|---|-------------------------------|--------------------------------------|---------------------|---------------------------------|------------------------|
| Өмнөговь аймгийн БОАЖГазарт | танилцуулах | ТЖБОМТ биелэлтийн тайланг тайлагнах | 10-р сарын 01 дотор | - | Аймгийн БОАЖГазарт |
| БОАЖЯ-ны ХБОБНГ-т | - | Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх | 12-р сар | - | - |

Тус төслийг хэрэгжүүлэх тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 4730.0 мян төгрөг төлөвлөж өглөө.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ДРИЙМ ГОВЬ
НЭРТЭЙ ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ)

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) Төсөл хэрэгжүүлэх нутаг нь Өмнөговь аймгийн Булган сумын нутаг Дал баг Хонгор толгойд “ЖАМОТОРАБЭРҮ” ХХК-ний ДРИЙМ ГОВЬ жуулчны бааз байгуулах төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Монгол Улсын хуулиудын дагуу “ЖАМОТОРАБЭРҮ” ХХК нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын яам /-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “ЖАМОТОРАБЭРҮ” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна

Хүснэгт 12. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналт шинжилгээ хийх байршил | Хугацаа ба давтамж | Шаардагдах зардал (мян.төг) | Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд |
|---|---|--|--|--|--|
| 1. Агаарын чанар | | | | | |
| 1.1 | Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх | Төсөл хэрэгжих талбайд хяналтын 1 цэг сонгох | Агаарын найрлага: жилд 1 удаа | Шинжилгээний зардал: 1 удаагийнх 50.0 х 2 цэг жилд 1удаа НИЙТ 100.0 | <ul style="list-style-type: none"> - MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, - MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга - MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ |
| 1.2 | Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | | Тоосны хяналт: төслийн талбайд 2 цэгт жилд 1удаа | | |
| 1.3 | Дуу шуугиан, чичиргээ: | | Жилд 1 удаа | | |
| 2. Усны хяналт шинжилгээ | | | | | |
| 2.1 | Усны ерөнхий шинжилгээ | Унд ахуйн уснаас | Жилд 1 удаа | 46.0*1 удаа=46,0 | <ul style="list-style-type: none"> - MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж - MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт |
| 3. Хөрсний бохирдол | | | | | |
| 3.1 | Хөрсний хими физик шинж чанар, хүнд металлын шинжилгээг хийлгэх | Төслийн талбайд 1 цэг сонгох | Жилд 1 удаа, 1 цэгт | 1х 2 дээж х жилд 1 удаа /22.0+28.0/ НИЙТ 72,0 /Хөрсний химийн шинжилгээ -44.0 төг, хүнд металлын шинжилгээ- 28.0 төг/ | <ul style="list-style-type: none"> - MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга - MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| ОХШХ-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын тухайн жилийн нийт зардлын дүн | | | | 218,0 | |

